



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 01 сарын 19-ны
өдрийн 3837 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 12 өдөр


Дугаар А/08

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.10.17 дахь заалт, “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2, 5.2.5 дахь заалт, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх ажлыг Түлшний бодлогын газрын дарга /Ч.Чулуунбат/-д даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журам” батлах тухай Уул уурхайн сайд /хуучнаар/-ын 2013 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 171 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Д.СУМЬЯАБАЗАР

Бүртгэлийн дугаар ...01...
МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
С. Золзори
2018 оны 01 сарын 12 ний одор

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБООТОЙ НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөнөөр болон жижиглэнгээр худалдах тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэдээ тайлан гаргах харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Энэхүү журам нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Барилгын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудад үндэслэж, тэдгээрт нийцсэн байна.

1.3. Энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэх бичиг баримт нь эх хувь эсхүл баталгаажуулсан /хүсэлт гаргахаас өмнө 30 хоногийн дотор/ хуулбар байна.

Хоёр. Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийн төрөл, хамрах хүрээ

2.1 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан зүйлсийг тусгана.

2.2 Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийг дараах төрлөөр олгоно. Үүнд:

2.2.1. Импортлох /Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн 27.10, 27.11 бүлгийн бүтээгдэхүүн / битум, мазут, тусгай шингэн, тос, тосолгооны материалаас бусад//,

2.2.2. Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн бөөний худалдаа,

2.2.3. Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн жижиглэнгийн худалдаа /Автобензин, дизелийн түлшийг шатахуун түгээх станц, автомашиныг шатдаг хийгээр цэнэглэх станцаар болон баллоноор худалдаалах/.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах

3.1 Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг энэхүү журмын дөрөвдүгээр зүйлд, тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтийг энэхүү журмын тавдугаар зүйлд заасан бичиг баримтын хамт газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

3.2 Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд агуулах, шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын техник, технологийн дүгнэлт гаргуулах хүсэлтийг энэхүү журмын зургаадугаар зүйлд заасан бичиг баримтын хамт газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ажлын 10 хоногт холбогдох дүгнэлтээ гаргана.

3.3 Хэрэв шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 3.2-д заасан хугацааг ажлын 5 хоногоор сунгаж болно.

3.4 Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын техник, технологийн дүгнэлтийг үндэслэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэлийн

гэрчилгээ олгоно. Бүртгэлийн мэдээллийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсаар мэдээлнэ.

3.5 Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц болон автомашин хийгээр цэнэглэх станцын бүртгэлийн гэрчилгээнд түүнийг олгосон он, сар, өдөр, дугаар, эзэмшигчийн нэр, байршил, хүчин чадал, бүтээгдэхүүний төрлийг тэмдэглэсэн байна.

3.6 Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдлийг холбогдох материалын хамт тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг баримт

4.1. Импортлох тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтуудыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

4.1.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2-т заасан тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт, тусгай зөвшөөрөл хүсэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ,

4.1.2. Холбогдох мэргэжлийн холбооны гишүүн хуулийн этгээд болохыг нотлох баримт,

4.1.3. Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гарал үүслийн гэрчилгээ /орчуулгын хамт/,

4.1.4. Өөрийн эзэмшлийн агуулахын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ,

4.1.5. Бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл,

4.1.6. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон агуулахын бүртгэлийн гэрчилгээ,

4.1.7. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тухайн агуулахад гаргасан техник, технологийн дүгнэлт,

4.1.8. Хуулийн этгээдийн дүрэм /хамгийн сүүлийн байдлаар улсын бүртгэлийн байгууллагаар баталгаажуулсан байна/,

4.1.9. Завсрын бүтээгдэхүүн /БТКУС-ын 27.10.12 90, 27.10.19 90, 27.10.20 90 г.м/ импортлох тохиолдолд газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл,

4.1.10. Бусад бичиг баримт /хуульд заасан үндэслэлээр/.

4.2. Бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтуудыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

4.2.1 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2-т заасан тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт, тусгай зөвшөөрөл хүсэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ,

4.2.2 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт,

4.2.3 Агуулахын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл хүчин төгөлдөр түрээсийн гэрээ,

4.2.4 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон агуулахын бүртгэлийн гэрчилгээ,

4.2.5 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тухайн агуулахад гаргасан техник, технологийн дүгнэлт,

4.2.6 Холбогдох мэргэжлийн холбооны гишүүн хуулийн этгээд болохыг нотлох баримт,

4.2.7 Хуулийн этгээдийн дүрэм /хамгийн сүүлийн байдлаар улсын бүртгэлийн байгууллагаар баталгаажуулсан байна/,

4.2.8 Бусад бичиг баримт /хуульд заасан үндэслэлээр/.

4.3. Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтуудыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

4.3.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2-т заасан тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт, тусгай зөвшөөрөл хүсэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ,

4.3.2. Холбогдох мэргэжлийн холбооны гишүүн хуулийн этгээд болохыг нотлох баримт,

4.3.3. Түгээх станцын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түгээх станцын хүчин төгөлдөр түрээсийн гэрээ,

4.3.4. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээ,

4.3.5. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тухайн агуулахад гаргасан техник, технологийн дүгнэлт,

4.3.6. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1-т заасан бичиг баримт,

4.3.7. Шатдаг хийг баллоноор жижиглэнгийн худалдаа эрхлэгчийн хувьд:

4.3.7.1. Баллон хадгалах завсрын агуулахын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл хүчин төгөлдөр түрээсийн гэрээ,

4.3.7.2. Онцгой байдлын газраас олгосон галын аюулгүй байдлын зөвшөөрөл,

4.3.7.3. Мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон ажлын байрны дүгнэлт,

4.3.7.4. Шатдаг хийн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ /бөөний худалдааны тусгай зөвшөөрөл эзэмшигч бол шаардлагагүй/,

4.3.8. Бусад бичиг баримт /хуульд заасан үндэслэлээр/

Тав. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад бүрдүүлэх бичиг баримт

5.1 Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад дараах бичиг баримтуудыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

5.1.1 Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай хүсэлт,

5.1.2 Холбогдох хууль болон энэхүү журмаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байсан талаарх газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт,

5.1.3 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт,

5.1.4 Түрээсийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд хүчин төгөлдөр түрээсийн гэрээ,

5.2 Тусгай зөвшөөрлийн төрлөөс хамаарч дараах нэмэлт бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

5.2.1 Импортлох тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, энэхүү журмын 4.1.4 - 4.1.6-д заасан бичиг баримт,

5.2.2 Бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тухайн агуулахад гаргасан техник, технологийн дүгнэлт, агуулахын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл эдгээрийн хүчин төгөлдөр түрээсийн гэрээ,

5.2.3 Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад техник, технологийн дүгнэлт, түгээх станцын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл хүчин төгөлдөр түрээсийн гэрээ,

5.2.4 Шатдаг хийн жижиглэнгийн худалдаа /баллоноор/ эрхлэх тусгай зөвшөөрөл сунгуулахад энэхүү журмын 4.3.7-д заасан бичиг баримт.

Зургаа. Агуулах, шатахуун түгээх станцын техник, технологийн дүгнэлт гаргуулахад бүрдүүлэх бичиг баримт

6.1. Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн агуулахын техник, технологийн дүгнэлт гаргуулахад дор дурдсан бичиг баримтуудыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

6.1.1. Техник, технологийн дүгнэлт гаргуулах хүсэлт,

6.1.2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ,

6.1.3. Стандартын шаардлага хангасан агуулахын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ,

6.1.4. Агаарын хөлгийн шатахууныг хадгалах зориулалтын агуулахад Иргэний нислэгийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулах эрх бүхий байгууллагаас гаргасан дүгнэлт,

6.1.5. Мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдын судалгаа,

6.1.6. Агуулахын газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лабораторийн судалгаа, эсхүл итгэмжлэгдсэн лабораторитай байгуулсан гэрээ,

6.1.7. Онцгой байдлын газраас олгосон галын аюулгүй байдлын зөвшөөрөл,

6.1.8. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1-т заасан бичиг баримт,

6.1.9. Мэргэжлийн байгууллага боловсруулж улсын экспертизээр баталгаажуулсан агуулахын зураг төсөл, газар эзэмших гэрчилгээ, улсын комисс хүлээн авсан акт,

6.1.10. Хадгалах савны ашиглалтын паспорт,

6.1.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ.

6.2. Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн түгээх станцын техник, технологийн дүгнэлт гаргуулахад дор дурдсан бичиг баримтуудыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

6.2.1. Техник, технологийн дүгнэлт гаргуулах хүсэлт,

6.2.2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ,

6.2.3. Газрын тосны бүтээгдэхүүний түгээх станцын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ,

6.2.4. Хэмжүүр, хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулсан бичиг баримт,

6.2.5. Онцгой байдлын газраас олгосон галын аюулгүй байдлын зөвшөөрөл,

6.2.6. Мэргэжлийн байгууллага боловсруулж, улсын экспертизээр баталгаажуулсан агуулахын зураг төсөл, газар эзэмших эрхийн гэрчилгээ, улсын комиссын хүлээн авсан акт,

6.2.7. Мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдын судалгаа,

6.2.8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ,

6.2.9. Хадгалах савны ашиглалтын паспорт.

Долоо. Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

7.1. Газрын тосны бүтээгдэхүүний импортын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

7.1.1. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн

7.1-д заасны дагуу хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах,

7.1.2. Импортын талаарх үнэн зөв мэдээллийг энэхүү журмаар батлагдсан маягтын дагуу сар бүрийн 10-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх,

7.1.3. Төрийн эрх бүхий байгууллагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг заасан хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж ирүүлэх.

Найм. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

8.1 Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

8.1.1 “Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу компанийн нөөцийг тогтоосон хугацаанд бүрэн бүрдүүлэх,

8.1.2 Газрын тосны бүтээгдэхүүний агуулахад өргөтгөл хийх тохиолдолд тухай бүр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад техник, технологийн дүгнэлт гаргуулахаар албан ёсоор мэдэгдэх,

8.1.3 Бүх төрлийн шатахуун болон шатдаг хийн бөөний борлуулалтын талаарх үнэн зөв мэдээллийг энэхүү журмаар батлагдсан маягтын дагуу дараа сар бүрийн 10-ны дотор, үлдэгдлийн мэдээг 7 хоног бүрийн Мягмар гаригт эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх,

8.1.4 Төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж хүргүүлэх.

Ес. Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

9.1 Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

9.1.1 Жижиглэнгийн худалдааны талаарх үнэн зөв мэдээллийг энэхүү журмаар батлагдсан маягтын дагуу дараа сар бүрийн 10-ны дотор, үлдэгдлийн мэдээг 7 хоног бүрийн Мягмар гаригт эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх,

9.1.2 Төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг заасан хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж хүргүүлэх,

9.1.3 Газрын тосны бүтээгдэхүүний худалдаанд хязгаарлалт хийсэн тохиолдолд энэ тухай 24 цагийн дотор газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр мэдэгдэх.

Арав. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

10.1 Энэхүү Журмын 7.1.3-д заасан мэдээ тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлээгүй, 8.1.1, 9.1.3-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

10.2 Тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлэх нөхцөл арилсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

10.3 “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлд заасан нөхцөл үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хүчингүй болгоно.

10.4 Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэр гарснаас

хойш 3 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харъяа дүүргийн Татварын алба, холбогдох бусад байгууллагуудад бичгээр мэдэгдэнэ.

Арван нэг. Бусад

11.1 Энэхүү журамд заасан техник, технологийн дүгнэлт, тодорхойлолтын үнэн зөв эсэхийг гаргасан байгууллага хариуцна.

11.2 Энэхүү журмын 11.1-т заасан техник, технологийн дүгнэлт, тодорхойлолтыг гаргахдаа хариуцлагагүй хандсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ын 41 дүгээр хавсралт



ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН ТОДОРХОИЛОЛТ

Эзэмшигчийн нэр: _____
 ГТБА-ын байршил: _____
 ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/: _____
 Удирдлагын нэр, албан тушаал: _____
 Холбогдох утас: _____

№	Нэг. Эрх зүйн бичиг баримтууд		бүрдэл	
1.	Газар эзэмших гэрчилгээний дугаар, огноо, эзэмших газрын хэмжээ			
2.	Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, огноо			
3.	Батлагдсан зураг төслийн шифр, боловсруулсан байгууллага, огноо			
4.	Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ			
5.	Бусад объектоос алслагдсан зай хэмжээ			
Хоёр. Техник технологийн байдал			үзүүлэлтүүд	
1.	Вагон эстакад			
д/д	бүрэлдэхүүн		хэмжих нэгж	хүчин чадал, марк
1.1	Байгууламж	төмөр замын урт	м	
		шат, тавцангийн урт	м	
		гэрэлтүүлэг	ш, вт	
		газардуулга	тайлбар	
		ослын сав, суваг	м3,м	
1.2	Коллектор	ДТ	диаметр	мм
			урт	м
		автобензин	диаметр	мм
			урт	м
		бусад:	диаметр	мм
	урт	м		
1.3	Ачих буулгах төхөөрөмж, /1 зэрэг/	шүүр, тунгаагуур		ш
		нийт тоо		ш
		дээгүүр буулгах		ш, м3/цаг
		дээгүүр ачих		ш, м3/цаг
		доогуур буулгах		ш, м3/цаг
		доогуур ачих		ш, м3/цаг
газардуулга		тайлбар		
2.	Автоцистернээс буулгах байгууламж			
2.1	Байгууламж	тэгш талбай, суваг		тайлбар
		ослын сав		ш, м3

		буулгах худаг	тайлбар	
		Шүүр тунгаагуур	ш	
		хаалт	ш	
		газардуулга	тайлбар	
		гэрэлтүүлэг	ш, кВт	
3.	Авто эстакад			
3.1	Байгууламж	саравч	ш	
		тэгш талбай	м2	
		шат, тавцан	ш, м	
		гэрэлтүүлэг	ш, вт	
3.2	Ачих төхөөрөмж	нийт тоо	ш	
		насос	ш	
		хаалт	тайлбар	
		шүүр тунгаагуур	ш	
		шингэний тоолуур	ш	
		газардуулга	тайлбар	
		илүүдлийн сав	ш, м3	
4.	Насос станц			
4.1	Насос	буулгах	тоо	
			марк	
			м3/цаг	
		ачих	тоо	
марк				
м3/цаг				
4.2	Барилга	үндсэн хийц	тайлбар	
		агааржуулалт	тайлбар	
		гэрэлтүүлэг	тайлбар	
		халаалт		
5.	Сав парк, шугам хоолой			
5.1	Сав	үйлдвэрлэсэн улс		тайлбар
		тоо		ш
		байрлал		тайлбар
		нийт багтаамж		м3
5.2	Байгууламжууд	далан,		хөрс, бетон
		талбай		хөрс, бетон
		суваг шуудуу		тайлбар
		ослын сав		ш, м3
5.3	Технологийн шугам хоолой	урт	А-80	м
			Аи-92	м
			ДТ	м
			ТС-1	м
		диаметр	А-80	мм
			Аи-92	мм
			ДТ	мм
			ТС-1	мм

6.	Бусад байгууламжууд		
6.1	Талбайн гэрэлтүүлэг	тэсрэлтийн хамгаалалттай	ш
			кВт
		суурин	тоо Вт
6.2	Гал унтраах багаж, тоног төхөөрөмж	усан сан	м3
		хөөсний нөөц	тн
		хөргөлтийн систем	тайлбар
		хөөсний систем	тайлбар
		ослын дохиолол	тайлбар
6.3	Савласан ГТБ хадгалах байр	барилга	м3
		талбай	м2
6.4	Цуглуулах, ууршуулах, цэвэрлэх байгууламж		тайлбар
6.5	Дохиолол, камер, харуул хамгаалалт		тайлбар
6.6	Хашаа		тайлбар
7.	Чанарын шинжилгээний лаборатори		
7.1	өөрийн	итгэмжлэгдсэн	тайлбар
7.2	Зөөврийн	баталгаажуулсан	тайлбар
7.3	гэрээт	итгэмжлэгдсэн	тайлбар
8.	ГТБ-ий хэмжил, тооцоолол, мэдээллийн автоматжуулалт		тайлбар
	Дүгнэлт		тайлбар

Жич:

1. Онгоцны шатахууны агуулахын хувьд олон улсын нислэгийн нийгэмлэгээс гаргасан зааврын шаардлагыг үндэслэж тодорхойлолт ирүүлнэ.

ГТБА эзэмшигчийг төлөөлж:

Гарын үсэг _____

Овог нэр _____

Албан тушаал _____

Он, сар, өдөр _____

Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 02 дугаар хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН
САВ ПАРКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**



Эзэмшигчийн нэр: _____
ГТБА-ын байршил: _____
ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ : _____
Удирдлагын нэр, албан тушаал: _____

№	Савны төрөл	Савны дугаар	Тоо	Хадгалах газрын тосны бүтээгдэхүүн	Тайлбар
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					

ГТБА эзэмшигчийг төлөөлж:
Гарын үсэг _____
Овог нэр _____
Албан тушаал _____
Он, сар, өдөр _____
Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 03 дугаар хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ
АГУУЛАХАД ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТҮВШИН ТОГТООСОН БАЙДАЛ**

1116127151
УХА0580 0120201

Эзэмшигчийн нэр: _____
ГТБА-ын байршил: _____
ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/: _____
Удирдлагын нэр, албан тушаал: _____

№	Шалгах үзүүлэлтүүд	
1	Чанарын шинжилгээний лабораторитой эсэх	
2	Чанарын шинжилгээний багаж хэрэгслийн хангалтын дундаж	
	А. ГТБ-ийг хүлээн авах, түгээх үеийн	
	Б. ГТБ-ий хадгалах үеийн хяналтын шинжилгээ хийх	
	В. ГТБ-ий хадгалах үеийн бүрэн шинжилгээ хийх	
3	Хүлээн авсан шатахуунд дагалдаж ирсэн шинжилгээний паспорт бүрэн эсэх (сүүлийн 5 сарын байдлаар импортоор, бөөнөөр хүлээж авсан)	
4	Шатахуун хүлээн авахад хийсэн чанарын шинжилгээний баримтууд байгаа эсэх (бөөнөөр хүлээж авсан, импортоор авсан)	
5	Ачигдаж байгаа шатахуунд чанарын шинжилгээний баримтууд дагалдуулдаг эсэх (бөөнөөр ачуулж байгаа)	
6	Чанарын хяналтын журнал хөтлөдөг эсэх	
7	Чанарын хяналтын дээж хадгалах тусгай байртай эсэх	
8	Чанарын хяналтын дээжийг хадгалдаг эсэх	
9	Чанарын шинжилгээний туршилтын аргын стандарт бичиг баримт бүрэн эсэх	
10	Лабораторийн галын анхан шатны багаж хэрэгслийн хангалт	
Ерөнхий дүн		

ГТБА эзэмшигчийг төлөөлж:

Гарын үсэг _____

Овог нэр _____

Албан тушаал _____

Он, сар, өдөр _____

Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 04 дүгээр хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ
АГУУЛАХЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИУДАД ТҮВШИН
ТОГТООХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

1116127151
УХА0580 9129294

Эзэмшигчийн нэр: _____
ГТБА-ын байршил: _____
ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ : _____
Удирдлагын нэр, албан тушаал: _____

№	Шалгах үзүүлэлт	
	Тийрэлтэт хөдөлгүүрийн түлш	
	А. Хүлээн авах ба түгээх үед	
1	Нягт	
2	Механик хольц	
3	Ус	
4	Кинематик зууралдлага /Цельсийн 20 хэм дэх/	
5	Найрлагын бүрэлдэхүүн	
	Б. Хяналтын шинжилгээнд	
6	Ноцох температур	
7	Усанд уусах хүчил шүлт	
8	Бодит давирхай	
9	Булингартах ба талсжиж эхлэх температур	
	В. Бүрэн шинжилгээнд	
10	Хүчиллэг чанар	
11	Зэс хавтгайн тушилт	
12	Дулааны тогтворшилт	
13	Хүхрийн хэмжээ /ТС-1-д/	
	Авто бензин	
	А. Хүлээн авах ба түгээхэд	
1	Өнгө ба тунгалаг байдал	
2	Нягт	
3	Октаны тоо	
4	Механик хольц ба ус	
	Б. Хяналтын шинжилгээнд	
6	Бодит давирхай	
7.	Найрлагын бүрэлдэхүүн	
	В. Бүрэн шинжилгээнд	
7	Усанд уусах хүчил шүлт	

8	Хүчиллэг чанар	
9	Зэс хавтгайн туршилт	
10	Ханасан уурын даралт	
	Дизелийн түлш	
	А. Хүлээн авах ба түгээхэд	
1	Нягт	
2	Механик хольц ба ус	
3	Цетаны тоо	
	Б. Хяналтын шинжилгээнд	
3	Найрлагын бүрэлдэхүүн	
4	Бодит давирхай	
5	20°C дахь зууралдлага чанар	
6	Булингартах ба талсжиж эхлэх температур	
7	Усанд уусах хүчил, шүлт	
8	Ноцох температур	
	В. Бүрэн шинжилгээнд	
9	Зэс хавтгайн туршилт	
10	Хүчиллэг чанар	
	Тусгай шингэн	
	А. Хүлээн авах ба түгээхэд	
1	Өнгө ба тунгалаг байдал	
2	Нягт	
3	Механик хольц ба ус	
	Б. Хяналтын шинжилгээнд	
4	Царцах температур	

ГТБА эзэмшигчийг төлөөлж:

Гарын үсэг _____

Овог нэр _____


Албан тушаал _____

Он, сар, өдөр _____

Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 05 дугаар хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН
ЛАБОРАТОРИД СУУРИЛУУЛСАН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ШИЛ
САВ, УРВАЛЖ МАТЕРИАЛЫН СУДАЛГАА**



Эзэмшигчийн нэр: _____
ГТБА-ын байршил: _____
ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ : _____
Удирдлагын нэр, албан тушаал: _____

№	Багаж, тоног төхөөрөмжийн нэр	Тоо	Марк	Үйлдвэрлэсэн улс	Суурилуулсан он сар	Зориулалт
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						

ГТБА эзэмшигчийг төлөөлж:

Гарын үсэг _____

Овог нэр _____


Албан тушаал _____

Он, сар, өдөр _____

Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тустай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 06 дугаар хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХУУДАД ХИЙГДСЭН
“БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН НАРИЙВЧИЛСАН
ҮНЭЛГЭЭ” -НИЙ ТАЛААРХ СУДАЛГАА**



Эзэмшигчийн нэр: _____
ГТБА-ын байршил: _____
ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ : _____
Удирдлагын нэр, албан тушаал: _____

Агуулахын байршил /хот, аймаг, сумын нэр/		
Компанийн нэр		
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн	Компанийн нэр	
	Он, сар, өдөр Дуусах хугацаа	
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, түүний биелэлтийн хэрэгжилт	Төлөвлөгөөт ажлын тоо, төсөвт хөрөнгө	
	Биелсэн	
	Төлөвлөгөөт ажлын тоо	
	Зарцуулсан хөрөнгө, төг	
	Биелээгүй	
	Төлөвлөгөөт ажлын тоо	
	Шалтгаан, тайлбар	

ГТБА эзэмшигчийг төлөөлж:

Гарын үсэг _____

Овог нэр _____

Албан тушаал _____


Он, сар, өдөр _____

Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ын 08 дугаар хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН ЗАХ ЗЭЭЛ,
БОРЛУУЛАЛТЫН СУДАЛГАА**

Эзэмшигчийн нэр: _____
 ГТБА-ын байршил: _____
 ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ : _____
 Удирдлагын нэр, албан тушаал: _____



ГТБ-ий нэр төрөл	Он	Ханган нийлүүлэгч	Гэвэрлэлтийн	Татан авалтын хэмжээ			Борлуулалт			Борлуулалтын хамрах
				Сар	Улирал	Жил	Сар	Улирал	Жил	
А-80	2016									
	2017									
	2018									
Аи-92	2016									
	2017									
	2018									
Аи-95	2016									
	2017									
	2018									
ДТ	2016									
	2017									
	2018									
ТС-1	2016									
	2017									
	2018									
Тос	2016									
	2017									
	2018									
Тусгай шингэн	2016									
	2017									
	2018									
ШШХ	2016									
	2017									
	2018									
Дүн										

ГТБА эзэмшигчийг төлөөлж:
 Гарын үсэг _____
 Овог нэр _____
 Албан тушаал _____
 Он, сар, өдөр _____
 Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 09 дүгээр хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН ГАМШИГ ОСОЛ, ГАЛ
ТҮЙМРЭЭС ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ, ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛСОН НОРМ, СТАНДАРТ, ДҮРМИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА**

УХА0580 9129294

Эзэмшигчийн нэр: _____
ГТБА-ын байршил: _____
ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ _____
Удирдлагын нэр, албан тушаал: _____

№	Агуулга			
1.	Агуулахын зураг төсөл	Баталгаажсан байдал		
		Орсон өөрчлөлт		
2.	Агуулахын зэрэглэл			
3.	Агуулахын нийт багтаамж			
4.	Зэргэлдээ байгууллагын барилга, байгууламж/ галын аюулгүйн зай хэмжээ			
5.	Агуулахын барилга байгууламжийн зай хэмжээ			
6.	Галын усан сан /м/, гидрант /ш/			
7.	Галын усны насос			
8.	Хөөс /тн/			
9.	Цахилгаан, хангамж, холбоо, дохиолол			
10.	Аянга зайлуулагч, газардуулгын байдал			
11.	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө			
12.	486 тоот захирамж, 2002 оны 100 дугаарт албан тоотын төлөвлөлт, түүний хэрэгжилт			
13.	үерийн далан, түймрийн зурвас /гамшгаас хамгаалагдсан байдал/			
14.	Гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл			

ГТБА эзэмшигчийг төлөөлж:

Гарын үсэг _____

Овог нэр _____

Албан тушаал _____

Он, сар, өдөр _____

Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 10 дугаар хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХУУДАД ХИЙГДСЭН
“ГАМШГИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ”-НИЙ
ТАЛААРХ СУДАЛГАА**

1116127151
УХА0580 9129294

Эзэмшигчийн нэр: _____
ГТБА-ын байршил: _____
ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ _____
Удирдлагын нэр, албан тушаал: _____

Агуулахын байршил /хот, аймаг, сум, лүүргийн нэр/		
Компаний нэр		
Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийсэн	Компаний нэр	
	огноо	
	Дуусах огноо	
Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээнд үндэслэсэн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилт	Биелсэн	
	Төлөвлөгөөт ажлын тоо,	
	Төлөвлөгөөт ажлын төсөв	
	Зарцуулсан хөрөнгө, төг	
	Биелээгүй ажлын тоо	
	Шалтгаан, тайлбар	

ГТБА эзэмшигчийг төлөөлж:

Гарын үсэг _____


Овог нэр _____

Албан тушаал _____

Он, сар, өдөр _____

Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 1 дүгээр хавсралт



**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ
БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ СУДАЛГАА**

Эзэмшигчийн нэр: _____
ГТБА-ын байршил: _____
ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ _____
Удирдлагын нэр, албан тушаал: _____

үзүүлэлт	тоон утга
Агуулахад хадгалагдаж байгаа газрын тосний бүтээгдэхүүний төрөл	
Гал тэсвэршилтийн зэрэг	
Тэсрэх аюулын концентрац %	
Тэсрэлтийн - дээд хязгаар % - доод хязгаар%	
Шатлагын температур °C	
Авалцан асах температур °C	
Гамшиг осол, гал түймэр үүсэх боломж	
Агуулахын металл хийцийн бүтэц	
Тэсрэлтийн орчин бүрдсэн эсэх	
Агуулахын диаметр, өндөр	
Агуулахын төрөл - ил - далд	
Хөнөөл учруулах бүсийн радиус, М	
Болзошгүй хохирлын хэмжээ, мян.төг	
Хөнөөлийн бүсд орших хүний тоо	
Хөнөөлийн бүсэд орших аж ахуйн нэгж байгууллага, тоо	
Хөнөөлийн бүсд орших аж ахуйн нэгж байгууллагын хохирол, мян.төг	

ГТБА эзэмшигчийг төлөөлж:

Гарын үсэг _____

Овог нэр _____


Албан тушаал _____

Он, сар, өдөр _____

Үзлэгийн ажлын хэсэг:

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 12 дугаар хавсралт

**АВТОМАШИН ШИНГЭРҮҮЛСЭН ШАТДАГ ХИЙГЭЭР ЦЭНЭГЛЭХ
СТАНЦЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ /АХЦС/**



АХЦС-ын эзэмшигч: _____
 АХЦС-ын байршил: _____
 АХЦС-ын удирдлага: _____
 Холбогдох утас: _____ Огноо: _____

Нэг	Эрх зүйн бичиг баримт	Дүн /0-100/	Тайлбар
1.	Газар эзэмших гэрчилгээний дугаар, огноо, газрын хэмжээ		
2.	Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, огноо		
3.	Батлагдсан зураг төслийн шифр, боловсруулсан байгууллага, огноо		
4.	ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ		
5.	АХЦС-ын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ		
6.	Хий хадгалах даралтат савыг улсын бүртгэлд хамруулж ашиглах зөвшөөрөл		
7.	БОНБН үнэлгээ хийсэн байгууллага, огноо		
8.	Галын аюулгүй ажиллагааны зөвшөөрөл		
9.	Түгээгүүрийн баталгаажилт		
10.	Аянга зайлуулагч, газардуулгын эсэргүүцлийг хэмжсэн баримт		
Хоёр	Техник, тоног төхөөрөмжийн шаардлагууд	Дүн /0-5/	Тайлбар
1.	Сав, шугам хоолойн аюулгүйн хавхлаг		
2.	Сав, шугам хоолойн хий алдагдлыг мэдрэгч		
3.	Түвшин хэмжигч		
4.	Манометр		
5.	Хамгаалах клапан		
6.	Түгээгүүрийн аюулгүйн холбогч		

7.	АХЦС-ын зам талбайн хатуу хучилт		
8.	Цахилгааны тэжээлийн холболт дүрмийн шаардлага хангах		
9.	Түгээгчийн байр		
10.	Сав, түгээгүүрийн саравч		
11.	ГТБ-ий үнийн самбар		
12.	Дохиолол, харуул хамгаалалт		
13.	Ослын автомат унтраалга		
Гурав	Баллон цэнэглэх цэг	Дүн /0-5/	Тайлбар
1.	Баталгаат жин		
2.	Хий алдагдлыг мэдрэгч		
3.	Агааржуулагч, сорох хоолой		
4.	Цэнэглэх байрны шал оч үсрэхээс хамгаалсан материалаар хийгдсэн		
Дөрөв	Зай хэмжээ /м/	Дүн /0-5/	Тайлбар
“Хийн хангамж” БНБД 42-01-04 8.126 заалт	АХЦС-ын хий хадгалах савнаас АХЦС-д хамаарахгүй барилга байгууламж хүртлэх зөвшөөрөгдөх зай хэмжээ		
	АХЦС-ын талбай дах барилга байгууламж хоорондын зөвшөөрөгдөх зай хэмжээ		
	Судалгаа		Тайлбар
1.	Савны багтаамж, тоо, байрлал		
2.	Шатахуун түгээх станц байгаа эсэх		
3.	Баллон хадгалах завсрын агуулах байгаа эсэх		
4.	ГТБ-ий хэмжил, тооцоолол, мэдээллийн автоматжуулалт		
5.	Түгээгүүр, хошууны тоо		
6.	Камер		
7.	Үйлчилгээний газар /дэлгүүр, тосны дэлгүүр, цайны газар, авто угаалага/		
8.	Нийтийн бие засах барих шаардлагатай эсэх		
НИЙТ ДҮН			

АХЦС эзэмшигчийг төлөөлж:

Үзлэгийн ажлын хэсэг:

Албан тушаал

“Газрын тосны бүтээгдэхүүний тугай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам”-ын 13 дугаар хавсралт

**ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН ТЕХНИКИЙН
ДҮГНЭЛТ ГАРГАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:
Шатахуун түгээх станцын байршил:
Шатахуун түгээх станцын удирдлага:
Холбогдох утас:

1116127151
УХА0580 9129294

Нэг.	Эрх зүйн бичиг баримтууд	Дүн /0-100/	Тайлбар
1.	Газар эзэмших гэрчилгээний дугаар, огноо, газрын хэмжээ, зориулалт		
2.	Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, огноо		
3.	ШТС-ын батлагдсан зураг төсөл. (<i>өрөнхий архитектор болон ОБЕГ-аар хянуулсан байна.</i>) - зураг төсөл боловсруулсан байгууллага, хянасан улсын экспертын дугаар - зураг төслийн шифр, дугаар, он сар		
4.	Улсын бүртгэлийн гэрчилгээ		
5.	Галын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан ажлын байрны дүгнэлт		
6.	ШТС-ын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ		
7.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт		
8.	Хэмжүүр хэмжих хэрэгслийг туршилтад хамруулсан баримт бичиг баталгаажилтууд		
9.	Аянга зайлуулагч, газардуулгыг жилд 2 удаа хэмжсэн баримт		
Дундаж дүн			

Хоёр	Техник, технологийн шаардлагууд	Дүн /0-100/	Тайлбар
1.	Галын анхан шатны багаж хэрэгсэл		
2.	Шатахуун хүлээн авах худаг		
3.	Бүтээгдэхүүний төрөл тус бүрийн хаалт		
4.	Бүтээгдэхүүний төрөл бүрт шүүр		
5.	Савны амьсгалах клапангууд бүрэн, хэвийн ажиллаж байгаа эсэх		
6.	Аянга зайлуулагч, газардуулгын сүлжээ хийгдсэн эсэх		
7.	Бусад объектоос алслагдсан зай хэмжээ		
8.	Шатахуун хүлээн авах тэгш талбай,		

	асгарсан шатахуун цуглуулах суваг		
9.	Автоцистерний газардуулга шаардлага хангасан эсэх		
10.	Буулгах хоолойн амны битүүмжлэлийг хангах		
11.	Савны хэмжих люк бүрэн		
12.	Зарлагын хоолойн задвижек бүрэн		
13.	Зарлагын хоолойн задвижек ажиллагаатай		
14.	Бүтээгдэхүүний төрөл тус бүрт түгээгүүртэй		
15.	Түгээгүүрийн арал стандартын шаардлага хангасан		
16.	Түгээгүүрийн хошуу нь цэнэглэж байгаа сав дүүрсэн тохиолдолд автоматаар хаагддаг байх		
17.	Түгээгүүрийг тээврийн хэрэгсэл мөргөх, уян хоолойноос чирэх тохиолдолд эвдрэх, шатахуун асгахаас хамгаалсан аюулгүйн таслагчтай байх		
18.	Ослын сав		
19.	Шаардлага хангасан түгээгчийн байр		
20.	ШТС-ын зам талбай хатуу хучилттай		
21.	Цэнэглэх талбайн саравч		
22.	Автоцистернээс ачаа буулгах үеийн ивүүр		
23.	ГТБ-ий үнийн самбар		
24.	Цахилгааны тэжээлийн холболт дүрмийн шаардлага хангах		
25.	ШТС-д галын аюулгүй бүс болохыг анхааруулсан тэмдэг замын тэмдэг, тэмдэглэгээтэй байна.		
26.	Мэргэжлийн боловсон хүчний хангалт		
Дундаж дүн			
	Судалгаа		
1.	ШТС-ын ашиглалтанд орсон он		
2.	Жижиглэн борлуулах шатахууны төрөл, тус бүрийн савны багтаамж м ³		
3.	Түгээгүүр болон хошууны тоо		
4.	Гал хамгаалагч бүрэн, эсэх		
5.	Түгээгүүрийн хөдөлгүүрт давтан газардуулга хийсэн		
6.	Шаардлага хангасан савны паркийн ба үерийн суваг / Үерийн бүсэд орсон газруудад хамааралтай/		

Гурав.	Технологийн шаардлагууд	Дүн /0-100/	Тайлбар
1.	Сав, шугам хоолойн битүүмжлэлийн шаардлага хангасан байдал		
2.	Хүлээн авсан шатахуунд дагалдах шинжилгээний паспорт		
3.	Шатахуун хүлээн авсан тооцоо бүртгэл		

4.	Савны шатахуунд шинжилгээ хийсэн баримт		
5.	Шатахууны төрөл бүрт тохирох денсиметр		
6.	Мерник /10л/		
7.	Сүмбэнметр /3м/		
8.	Шаардлага хангасан дээж авах бортого		
9.	Анхан шатны бүртгэлүүдийн хөтлөлт		
Дундаж дүн			
Судалгаа			
1.	Үйлчилгээний орчны ариун цэвэр		
2.	ГТБ-ээр бохирдсон зам талбайг цэвэрлэх арга хэмжээний хэлбэрүүд		
3.	Ой, хээрийн түймэр гарах магадлалтай бүсэд хамгаалах зурвасыг стандартын дагуу татсан эсэх		
4.	Дохиолол, харуул хамгаалалт		
5.	ГТБ-ий хэмжил, тооцоолол, мэдээллийн автоматжуулалт		
Нийт дүн			

Үзлэг хийсэн: /...../

/албан тушаал/

/овог нэр/

ШТС-ын эзэмшигчийг төлөөлж:


Гарын үсэг _____

Овог нэр _____

Албан тушаал _____

Он, сар, өдөр _____

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ын 14 дүгээр хавсралт



ҮЛДЭГДЛИЙН МЭДЭЭ

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

Тайлант хугацаа: оны -р сарын-с оны-р сарын ... өдөр

Агуулах, ШТС-ын байршил		Агуулахын үлдэгдэл /тн/					ШТС-ын үлдэгдэл /тн/					Агуулахын үнэ, (литр/төг)					ШТС-ын үнэ, (литр/төг)			
Хот, аймаг	Сум, дүүрэг	Н-80	Р-92	П-95,98	ДТ	ТС-1	Н-80	Р-92	П-95,98	ДТ	Н-80	Р-92	П-95,98	ДТ	ТС-1	Н-80	Р-92	П-95,98	ДТ	
Нийт дүн																				

Анхаарах:

1. Үлдэгдэлийн тайланг долоо хоног бүрийн Мягмар гаригт хот, аймаг, төрөл тус бүрээр гаргаж эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан АМГТГ-т хүргүүлнэ.
2. Үлдэгдэл, үнийг тухайн өдрийн дүнгээр шивнэ.
3. Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь тухайн агуулахад хадгалагдаж байгаа үлдэгдэл болно.
4. Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь тухайн аймаг, хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийт ШТС-д хадгалагдаж байгаа үлдэгдэл болно.

Мэдээ гаргасан:

.....
Албан тушаалтан

.....
Овог нэр,

/...../
гарын үсэг

Тэмдэг

.....он.....сар.....өдөр

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ын 15 дугаар хэвсрэлт

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД БОРЛУУЛЖ БУЙ ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИЖИГЛЭН БОЛОН БӨӨНИЙ ҮНЭ

УТБ12/151
УХА058Д3/2014

№	Бүсийн нэр	Тулгуур төв	Аймаг, хотын нэр	А-80 /литр/		АИ-92 /литр/		АИ-95 /литр/					
				Жижиглэнгийн үнэ	Бөөний үнэ	Жижиглэнгийн үнэ	Бөөний үнэ	Жижиглэнгийн үнэ	Бөөний үнэ	Жижиглэнгийн үнэ	Бөөний үнэ		
1	Баруун бүс	Ховд, Улиастай											
2													
3													
4													
5													
Баруун бүсийн дундаж үнэ				0	0	0	0			0	0		
6	Хангайн бүс	Хархорин, Эрдэнэт											
7													
8													
9													
10													
11													
12													
Хангайн бүсийн дундаж үнэ				0	0	0	0	0	0	0	0	0	
13	Төвийн бүс	Зуунмод, Дархан											
14													
15													
16													
17													
18													
19													
20													
Төвийн бүсийн дундаж үнэ				0	0	0	0	0	0	0	0	0	
21	Зүүн бүс	Чойбалсан, Өндөрхаан											
22													
23													
Зүүн бүсийн дундаж үнэ				0	0	0	0			0	0		
Улсын дундаж үнэ				0	0	0	0	0	0	0	0	0	

Анхаарах:

- Газрын тосны бүтээгдэхүүний бөөн болон жижиглэнгийн үнийн мэдээг тухайн сард хот, аймаг, төрөл тус бүрээр гаргаж дараа сарын 10-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан АМГТГ-т хүргүүлнэ.
- Газрын тосны бүтээгдэхүүний бөөн болон жижиглэнгийн үнийн мэдээ мэдээг үйл ажиллагаа явуулж байгаа хот, аймаг тус бүрээр гаргах ба тонноор тооцож шивнэ.

Мэдээ гаргасан: /...../ Тэмдэг
 Албан тушаалтан Овог нэр, гарын үсэг
он.....сар.....өдөр

"Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам"-ын 16 дугаар хавсралт

ИМПОРТЫН МЭДЭЭ

ААН-ийн нэр:

Тайлант хугацаа:

20...оны...-р сарын....-с 20...оны...-р сарын...өдөр

Д/д	Нийлүүлэгч эх үүсвэр		Бүтээгдэхүүний төрөл	Огноо	Нэгж	Импортлосон боомт
	Улс	Компани				
Нийт						

Анхаарах

- Газрын тосны бүтээгдэхүүний импортын мэдээг нийлүүлэгч эх үүсвэр тус бүрээр, бүтээгдэхүүний төрөл, бүтээгдэхүүний хэмжээ, импортлосон боомт бүрээр тус бүр гаргаж сар бүрийн 5-ны дотор АМГТГ-т эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.
- Бүтээгдэхүүний импортлосон хэмжээг тонноор тооцож шивнэ.

Мэдээ гаргасан:

.....
Албан тушаал

.....
овог нэр,

.....
гарын үсэг /Гэмдэг

.....он.....сар.....өдөр

БӨӨНИЙ БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

ААН-ийн нэр:

Тайланг хугацаа:

20...оны...-р сарын...-с 20...оны...-р сарын...өдөр

УХА0580 9129294

Д/д	Огноо	Хот, аймаг	Агуулах ын нэр	Борлуулалт /тонноор/				Нийт борлуула лт
				90-ээс доош октантай автобензи н	90-ээс дээш октантай автобензи н	Дизелийн түлш	Онгоцны түлш	
1								
2								
3								
Нийт								

Анхаарах

- Бөөний борлуулалтын тайланг тухайн сард хот аймаг, агуулах тус бүрээр гаргаж дараа сарын 10-ны дотор АМГТГ-т эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.
- Бөөний борлуулалтын тайланг үйл ажиллагаа явуулж байгаа хот аймаг, агуулах тус бүрээр гаргах ба борлуулсан хэмжээг тонноор тооцож шивнэ.

Мэдээ гаргасан:

.....
Албан тушаал

.....
овог нэр,

.....
гарын үсэг /Тэмдэг


.....он.....сар.....өдөр

ЖИЖИГЛЭНГИЙН БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

ААН-ийн нэр:

Тайлант хугацаа:

20...оны...-р сарын...-с 20...оны...-р сарын...өдөр



Д/д	Огноо	Хот, аймаг	ШТС-ын нэр	Борлуулалт /тонноор/				Нийт борлуулалт
				90-ээс доош октантай автобензин	90-ээс дээш октантай автобензин	Дизелийн түлш	Онгоцны түлш	
1								
2								
3								
Нийт								

Анхаарах

1. Жижиглэнгийн борлуулалтын тайланг тухайн сард хот аймаг, ШТС тус бүрээр гаргаж дараа сарын 10-ны дотор АМГТГ-т эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.
2. Жижиглэнгийн борлуулалтын тайланг үйл ажиллагаа явуулж байгаа хот аймаг, ШТС тус бүрээр гаргах ба борлуулсан хэмжээг тонноор тооцож шивнэ.

Мэдээ гаргасан:


.....
Албан тушаал

.....
овог нэр,

.....
гарын үсэг /Тэмдэг

.....он.....сар.....өдөр

ШАТДАГ ХИЙН ҮЛДЭГДЛИЙН МЭДЭЭ



ААН-ийн нэр:

Тайлант хугацаа:

20...оны...-р сарын...-с 20...оны...р сарын...өдөр

Д/д	Хот, аймаг	ХЦС-ын үлдэгдэл /тн/		АХЦС-ын үлдэгдэл /тн/		ХЦС-ын үнэ		АХЦС-ын үнэ	
		Ахуйн хэрэглээ ний хий	Автомашин хий	Ахуйн хэрэглээ ний хий	Автомашин хий	Ахуйн хэрэглээ, (кг/төг)	Автомашин (литр/төг)	Ахуйн хэрэглээ, (кг/төг)	Автомашин (литр/төг)
1									
2									
3									
Нийт дүн									

Анхаарах:

1. Шатдаг хийн үлдэгдэл, үнийн мэдээг тухайн сард аймаг хот, төрөл тус бүрээр гаргаж дараа сарын 10-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан АМГТГ-т хүргүүлнэ.
2. Шатдаг хийн үлдэгдэл, үнийг тухайн өдрийн дүнгээр шивнэ.
3. ХЦС- Хий цэнэглэх станц болно.
4. АХЦС- Автомашиныг хийгээр цэнэглэх станц болно.

Мэдээ гаргасан:

.....
Албан тушаал

.....
овог нэр,

.....
гарын үсэг /Тэмдэг

.....он.....сар.....өдөр

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам-ын 20 дугаар хавсралт

ШАТДАГ ХИЙН БӨӨНИЙ БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

ААН-ийн нэр:

Тайлант хугацаа:

20...оны...-р сарын...-с 20...оны...-р сарын...өдөр

УХА0580 9129294

Д/д	Хот, аймаг	ХЦС-ын борлуулалт /тонноор/		Нийт борлуулалт
		Автомашины хий	Ахуйн хэрэглээний хий	
Нийт дүн				

Анхаарах:

1. Шатдаг хийн бөөний борлуулалтын мэдээг тухайн сард хот, аймаг, төрөл тус бүрээр гаргаж дараа сарын 10-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан АМГТГ-т хүргүүлнэ.
2. Шатдаг хийн бөөний борлуулалтын мэдээг үйл ажиллагаа явуулж байгаа хот, аймаг тус бүрээр гаргах ба тонноор тооцож шивнэ.
3. ХЦС- Хий цэнэглэх станц болно.

Мэдээ гаргасан:

.....
Албан тушаал

.....
овог нэр,

.....
гарын үсэг /Тэмдэг

.....он.....сар.....өдөр

“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ын 21 дүгээр хавсралт

ШАТДАГ ХИЙН ЖИЖИГЛЭНГИЙН БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

ААН-ийн нэр:

Тайлант хугацаа:

20...оны...-р сарын....-с 20....оны...-р сарын...өдөр

116127151
УХА0580 9129294

Д/д	Хот, аймаг	Борлуулалт /тонноор/		Нийт борлуулалт
		Автомашины хий	Ахуйн хэрэглээний хий	
1				
2				
3				
Нийт				

Анхаарах:

1. Шатдаг хийн жижиглэнгийн борлуулалтын мэдээг тухайн сард хот, аймаг, төрөл тус бүрээр гаргаж дараа сарын 10-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан АМГТГ-т хүргүүлнэ.
2. Шатдаг хийн жижиглэнгийн борлуулалтын тайланг үйл ажиллагаа явуулж байгаа хот, аймаг тус бүрээр гаргах ба борлуулсан хэмжээг тонноор тооцож шивнэ.

Мэдээ гаргасан:

.....
Албан тушаал

.....
овог нэр,

.....
гарын үсэг /Гэмдэг

.....он.....сар.....өдөр

ШАТДАГ ХИЙН ИМПОРТЫН МЭДЭЭ

ААН-ийн нэр:

Тайлант хугацаа:

20...оны...-р сарын...-с 20...оны...-р сарын...өдөр

УХА0580 9129294

Д/ д	Бүтээгдэхүүний төрөл	Нийлүүлэгч эх үүсвэр		Бүтээгдэхүүний хэмжээ /тн/ Хил үнэ /\$/	Импортолсон боомт
		Улс	Компани		
1	Пропан				
2	Бутан				
3	Холимог				
4	Бусад шатдаг хий				

Анхаарах:

1. Шатдаг хийн импортын мэдээг тухайн сард нийлүүлэгч эх үүсвэр, бүтээгдэхүүний төрөл, бүтээгдэхүүний хэмжээ, үнэ, импортолсон боомт тус бүрээр гаргаж дараа сарын 10-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан АМГТГ-т хүргүүлнэ.
2. Шатдаг хийн импортолсон хэмжээг тонноор тооцож шивнэ.

Мэдээ гаргасан:

.....
Албан тушаал

.....
овог нэр,

.....
гарын үсэг /Тэмдэг

.....он.....сар.....өдөр

"Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй
холбоотой нарийвчилсан журам"-ын 23 дугаар хэвсрэлт

МЭДЭЭ ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ХУВААРЬ

№	Мэдээ, мэдээллийн төрөл	Хугацаа	Хаана хүргүүлэх	Танилцуулах байгууллага
1	Газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдэл нөөцийн мэдээ	7 хоног бүрийн 2 дахь өдөр	АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэст	УУХҮЯ, ҮАБЗөвлөл, АМГТГ, ТЕГ, ШӨХТГ, Сангийн яам
2	Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэн болон бөөний үнийн мэдээ, төг /ШТС-аар, хот, аймгаар/	7 хоног бүрийн 2 дахь өдөр	АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэст	УУХҮЯ, ҮАБЗөвлөл, АМГТГ, ТЕГ, ШӨХТГ, Сангийн яам
3	Газрын тосны бүтээгдэхүүний импортолж буй импортын мэдээг нийлүүлэгч, эх үүсвэрээр, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанарын паспорт, хилийн үнэ, импортолсон боомт тус бүрээр	Сар бүрийн 10-ны дотор	АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэст	УУХҮЯ, ҮАБЗөвлөл, АМГТГ, ТЕГ, ШӨХТГ, Сангийн яам
4	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалтын мэдээ /агуулах, хот, аймаг, төрөл тус бүрээр/	Сар бүрийн 10-ны дотор	АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэст	УУХҮЯ, ҮАБЗөвлөл, АМГТГ, ТЕГ, ШӨХТГ, Сангийн яам
5	Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн борлуулалтын мэдээ /ШТС, хот, аймаг, төрөл тус бүрээр/	Сар бүрийн 10-ны дотор	АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэст	УУХҮЯ, ҮАБЗөвлөл, АМГТГ, ТЕГ, ШӨХТГ, Сангийн яам
6	Шингэрүүлсэн шатдаг хийн үлдэгдэл, үнийн мэдээ / хот, аймаг, төрөл тус бүрээр/	7 хоног бүрийн 2 дахь өдөр	АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэст	Ашигт малтмал, газрын тосны газар
7	Шингэрүүлсэн шатдаг хийн бөөний борлуулалтын мэдээ / хот, аймаг, төрөл тус бүрээр/	Сар бүрийн 10-ны дотор	АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэст	Ашигт малтмал, газрын тосны газар
8	Шингэрүүлсэн шатдаг хийн жижиглэнгийн борлуулалтын мэдээ / хот, аймаг, төрөл тус бүрээр/	Сар бүрийн 10-ны дотор	АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэст	Ашигт малтмал, газрын тосны газар
9	Шингэрүүлсэн шатдаг хийн импортын мэдээ / нийлүүлэгч эх үүсвэр, төрөл, бүтээгдэхүүний хэмжээ, хилийн үнэ, импортолсон боомт тус бүрээр /	Сар бүрийн 10-ны дотор	АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэст	Ашигт малтмал, газрын тосны газар